



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 99029193
Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 99035990
Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК
Захирал: А.Сарангэрэл
Утас: 9988 4842
Цахим хаяг: gereltekhburtgelaudit01@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Төлбөрийн акт.....	15
4.2 Албан шаардлага.....	15
4.3 Зөвлөмж.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 102
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЖААХАН
ШАРГА ТЕАТРЫН ДАРГА
Г.БАЯРЦОГТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаахан шарга театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаахан шарга театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		/Төгрөгөөр/	
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	219,947,545.37	233,456,305.73
33	АВЛАГА	5,590,116.64	5,549,240.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	40,876.64	-
335	Бусад авлага	5,549,240.00	5,549,240.00
3351	Байгууллагаас авах авлага	5,549,240.00	5,549,240.00
34	УРЬДЧИЛГАА	2,124,500.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	2,124,500.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	212,232,928.73	227,907,065.73
351	Түүхий эд материал	66,646,235.40	69,976,235.40
35200	Тусгай зориулалттай материал	66,646,235.40	69,976,235.40
354	Хангамжийн материал	145,586,693.33	157,930,830.33
35410	Бичиг хэргийн материал	200,000.00	200,000.00
35420	Аж ахуйн материал	32,868,142.00	35,532,881.00
35470	Бусад хангамжийн материал	112,518,551.33	122,197,949.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,693,218,458.76	2,610,994,598.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,693,218,458.76	2,610,994,598.44
392	Биет хөрөнгө	2,633,314,458.76	2,551,090,598.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,554,787,648.00	2,554,787,648.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,344,784.92)	(180,146,733.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,800,000.00	73,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,769,444.83)	(23,311,111.14)
39205	Машин тоног төхөөрөмж	319,991,545.14	289,643,292.14
39206	Хуримтлагдсан элэгдэл	(207,561,176.60)	(184,211,624.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	114,090,429.60	115,740,429.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(83,679,757.63)	(94,711,301.48)
393	Биет бус хөрөнгө	59,904,000.00	59,904,000.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хасагдуулга	(750,000.00)	(750,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	59,904,000.00	59,904,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,913,166,004.13	2,844,450,904.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,290,259.00	2,290,259.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,290,259.00	2,290,259.00
413	Өглөг	2,290,259.00	2,290,259.00
4136	Бусад өглөг	2,290,259.00	2,290,259.00
41361	Байгууллагад төлөх өглөг	434,000.00	434,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,856,259.00	1,856,259.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,910,875,745.13	2,842,160,645.17
51	Засгийн газрын хувь оролцоо	2,910,875,745.13	2,842,160,645.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	906,369,876.63	906,369,876.63
51101	Өмч: - төрийн	906,369,876.63	906,369,876.63
512	Хуримтлагдсан үр дүн	(14,110,313.53)	(80,736,013.49)
51210	Өмнөх үеийн үр дүн	(14,110,313.53)	(12,020,913.53)
51220	Тайлант үеийн үр дүн		(68,715,099.96)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,018,616,182.03	2,016,526,782.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,913,166,004.13	2,844,450,904.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,298,115,100.00	1,308,506,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,520,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	59,520,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,520,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,520,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,238,595,100.00	1,308,506,750.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,114,000.00	7,221,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,500,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,614,000.00	7,221,650.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,222,481,100.00	1,301,285,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,222,481,100.00	1,301,285,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,396,449,232.92	1,377,221,849.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,396,449,232.92	1,377,221,849.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,332,526,736.88	1,347,714,804.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	692,095,084.54	780,585,472.85
210101	Үндсэн цалин	692,095,084.54	780,585,472.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,597,600.00	100,809,930.63
210201	Тэтгэврийн даатгал	65,865,000.00	70,777,815.57
210202	Тэтгэмжийн даатгал	8,483,200.00	7,886,623.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,546,500.00	6,289,138.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,386,600.00	1,441,486.90
210205	Эрүүл мэндийн даатгал	12,316,300.00	14,414,866.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,579,963.00	296,411,357.50
210301	Гэрэл, цахилгаан	7,549,511.00	5,884,119.00
210302	Түлш, халаалт	285,040,572.00	286,527,238.50
210303	Цэвэр, бохир ус	3,989,880.00	4,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,199,314.02	32,918,099.93
210401	Бичиг хэрэг	2,572,589.00	2,498,950.00
210402	Тээвэр, шатахуун	10,365,484.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,458,650.00	951,748.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,351,332.00	5,127,900.00
210408	Бараа материал акталсны зардал	35,451,259.02	16,839,501.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,120,248.00	26,343,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,387,000.00	1,344,900.00
210604	Урсгал засвар	12,733,248.00	24,998,440.00
2107	Томилот, зочны зардал	1,579,000.00	1,768,000.00
210702	Дотоод албан томилот	1,579,000.00	1,768,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,353,071.00	23,533,376.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,792,450.00	18,538,031.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	955,200.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,850.00	137,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,500.00	164,600.00

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,600.00	31,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,894,071.00	3,438,421.00
210807	Газрын төлбөр	359,400.00	359,424.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,002,456.32	85,345,227.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,193,559.40	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,194,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,614,896.92	85,345,227.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,922,496.04	29,507,045.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,109,000.00	3,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,209,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,900,000.00	3,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,813,496.04	26,407,045.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,813,496.04	26,407,045.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(98,334,132.92)	(68,715,099.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(98,334,132.92)	(68,715,099.96)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	846,465,876.63	9,035,605.66	(67,761,614.54)	787,739,867.75
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,386,360.78	2,386,360.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	846,465,876.63	9,035,605.66	(65,375,253.76)	790,126,228.53
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-		-	(2,386,360.78)
C07	Тайлант үеийн үр дүн			76,104,824.30	76,104,824.30
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,018,616,182.03	(14,110,313.53)	2,910,875,745.13
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,018,616,182.03	(14,110,313.53)	2,910,875,745.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		2,089,400.00	2,089,400.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	906,369,876.63	2,018,616,182.03	(12,020,913.53)	2,912,965,145.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,089,400.00)	-	(2,089,400.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-		(68,715,099.96)	(68,715,099.96)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	906,369,876.63	2,016,526,782.03	(80,736,013.49)	2,842,160,645.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,238,595,100.00	1,308,506,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,238,595,100.00	1,308,506,750.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,114,000.00	7,221,650.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,500,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,614,000.00	7,221,650.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,222,481,100.00	1,301,285,100.00

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,222,481,100.00	1,301,285,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,226,975,200.00	1,296,151,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,226,975,200.00	1,296,151,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,163,052,703.96	1,266,644,504.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	691,775,871.96	780,544,596.21
210101	Үндсэн цалин	691,775,871.96	780,544,596.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,597,600.00	100,809,930.63
210201	Тэтгэврийн даатгал	65,865,000.00	70,777,815.57
210202	Тэтгэмжийн даатгал	8,483,200.00	7,886,623.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,546,500.00	6,289,138.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,386,600.00	1,441,486.90
210205	Эрүүл мэндийн даатгал	12,316,300.00	14,414,866.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,579,963.00	296,411,357.50
210301	Гэрэл, цахилгаан	7,549,511.00	5,884,119.00
210302	Түлш, халаалт	285,040,572.00	286,527,238.50
210303	Цэвэр, бохир ус	3,989,880.00	4,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,296,814.00	16,078,598.00
210401	Бичиг хэрэг	2,434,280.00	2,498,950.00
210402	Тээвэр, шатахуун	10,365,484.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,458,650.00	951,748.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,038,400.00	5,127,900.00
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,026,005.00	26,892,340.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,168,600.00	1,893,900.00
210604	Урсгал засвар	12,857,405.00	24,998,440.00
2107	Томилолт, зочны зардал	1,579,000.00	1,768,000.00
210702	Дотоод албан томилолт	1,579,000.00	1,768,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,003,450.00	43,139,682.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,524,500.00	38,183,316.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	955,200.00	864,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,850.00	137,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,500.00	164,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	37,600.00	31,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,812,400.00	3,399,442.00
210807	Газрын төлбөр	359,400.00	359,424.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,194,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,194,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,922,496.04	29,507,045.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,109,000.00	3,100,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,209,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,900,000.00	3,100,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,813,496.04	26,407,045.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,813,496.04	26,407,045.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,619,900.00	12,355,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,619,900.00	12,355,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,619,900.00	12,355,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,619,900.00	12,355,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,619,900.00	12,355,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,619,900.00)	(12,355,200.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,301,285,100.00	1,275,399,704.34	25,885,395.66	98.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,301,285,100.00	1,275,399,704.34	25,885,395.66	98.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,298,185,100.00	1,272,299,704.34	25,885,395.66	98.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	797,444,900.00	780,544,596.21	16,900,303.79	97.88
210101	Үндсэн цалин	693,644,900.00	780,544,596.21	(86,899,696.21)	112.53
210102	Нэмэгдэл	103,800,000.00		103,800,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,655,100.00	100,809,930.63	6,845,169.37	93.64
210201	Тэтгэврийн даатгал	75,757,300.00	70,777,815.57	4,979,484.43	93.43
210202	Тэтгэмжийн даатгал	7,974,500.00	7,886,623.35	87,876.65	98.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,379,500.00	6,289,138.23	90,361.77	98.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,594,900.00	1,441,486.90	153,413.10	90.38
210205	Эрүүл мэндийн даатгал	15,948,900.00	14,414,866.58	1,534,033.42	90.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	297,618,700.00	296,411,357.50	1,207,342.50	99.59
210301	Гэрэл, цахилгаан	7,700,000.00	5,884,119.00	1,815,881.00	76.42
210302	Түлш, халаалт	285,918,700.00	286,527,238.50	(608,538.50)	100.21
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,607,500.00	16,078,598.00	528,902.00	96.82
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,498,950.00	1,050.00	99.96
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,000.00	951,748.00	498,252.00	65.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,157,500.00	5,127,900.00	29,600.00	99.43
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,500,000.00	36,497,540.00	2,460.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,500,000.00	11,499,100.00	900.00	99.99
210604	Урсгал засвар	25,000,000.00	24,998,440.00	1,560.00	99.99
2107	Томилолт, зочны зардал	2,163,900.00	1,768,000.00	395,900.00	81.70
210702	Дотоод албан томилолт	2,163,900.00	1,768,000.00	395,900.00	81.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,195,000.00	39,189,682.00	5,318.00	99.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,237,500.00	34,233,316.00	4,184.00	99.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	864,000.00	864,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	137,600.00	137,600.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	164,600.00	164,600.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	31,300.00	31,300.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,400,000.00	3,399,442.00	558.00	99.98
210807	Газрын төлбөр	360,000.00	359,424.00	576.00	99.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,100,000.00	3,100,000.00	-	100.00

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2132	Бусад урсгал шилжүүлэг	3,100,000.00	3,100,000.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,100,000.00	3,100,000.00	-	100.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,301,285,100.00	(1,301,285,100.00)	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	1,301,285,100.00	(1,301,285,100.00)	
132001	Орон нутгийн төсвөөс		1,301,285,100.00	(1,301,285,100.00)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Тайлант оны	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,700,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,700,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,700,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,700,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,700,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,221,650.00	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,221,650.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторын туслах Э.Алтангэрэл, аудиторын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр нь Монголын соёл урлагийн салбарын хөгжилд хувь нэмэр оруулах, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц уран бүтээлээр үзэгчдэд үйлчлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 27,928.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22,343.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 27,544.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 22,035.5 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 384.5 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5,590.1	5,549.2	(40.9)
Урьдчилгаа	2,124.5	-	(2,124.5)
Бараа материал	212,232.9	227,907.1	15,674.2
Үндсэн хөрөнгө	2,693,218.5	2,610,994.6	(82,223.9)
Нийт хөрөнгө	2,913,166.0	2,844,450.9	(68,715.1)
Өр төлбөр	2,290.3	2,290.3	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,910,875.7	2,842,160.6	(68,715.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,913,166.0	2,844,450.9	(68,715.1)

Авлага дансны үлдэгдэлд он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй 5,549.2 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 227,907.1 мянган төгрөг болж, 15,674.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,610,994.6 мянган төгрөг болж, 82,223.9 мянган төгрөгөөр буурсан. Үндсэн хөрөнгийн данс худалдан авсан 14,479.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталж устгасан 68,677.9 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагджээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 10,445.7 мянган төгрөгөөр өссөн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 59,520.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардал өмнөх оноос 19,227.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа үйлчилгээний бусад зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,824,908.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,824,908.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 523,623.8 мянган төгрөгөөр бууруулж, 1,301,285.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,301,285.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,301,285.1 мянган орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,301,285.1 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 1,301,285.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,275,399.7

мянган төгрөгийг зарцуулж, 29,885.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үзвэр үйлчилгээ, заалны түрээсийн 7,221.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 6,700.0 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 521.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театр нь 2021 онд нийт 1,588,246.1 мянган төгрөгийн 26 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,420,536.5 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад орон тоо нэмэгдээгүй, хөрөнгө бэлтгээгүй байна

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 алдаа зөрчил илэрснээс 7,880.3 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд албан шаардлага, 2 алдаа зөрчилд зөвлөмж өгснөөс зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувь хэрэгжиж, 1 албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	1	7,880.3	-	-	1	7,880.3	100.0
Зөвлөмж	2	-	2	-	-	-	-
Нийт дүн	3	7,880.3	2	-	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,435,140.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,163.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,601.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,420,536.5 мянган төгрөгийн шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой, 5,549.2 мянган төгрөгийн авлага болон 2,290.3 мянган төгрөгийн өр төлбөртэй холбоотой зөвлөмж өгөв.

4.1 Төлбөрийн акт

Хөдөлмөрийн чадвар алдалтын акттай 1 ажилтаны нэгдүгээр сарын цалингаас НДШ-г 12.5 хувиар тооцоноос 24.4 мянган төгрөгийг илүү, 1-12 дугаар сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцоноос 1,138.9 мянган төгрөгийг илүү суутгасан.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, 25 дугаар зүйлийн 25.3-т “суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод

албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.2 Албан шаардлага

Нийт 7 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 4,416.5 мянган төгрөгийн, 3 хувь хүмүүстэй холбоотой 1,184.8 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өглөгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Өр төлбөр дансны үлдэгдэлд 7 байгууллагад өгөх нийт 2,290.3 мянган төгрөгийн он дамжсан өр төлбөр бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж өр төлбөр үүсгэхгүй төсвийг зохистой удирдан ажиллах, үүссэн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, өр төлбөр үүрссэнийг нотолсны дараа барагдуулах

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Авлага дансны үлдэгдэлд он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй 5,549.2 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах..." 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

2.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж авлага үүсгэхгүй төсвийг зохистой удирдан ажиллах, үүссэн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж баримтжуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ зохион байгуулах

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2021 онд нийт 1,588,246.1 мянган төгрөгийн 26 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,420,536.5 мянган төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-д 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Цалинг буруу тооцоолж олгосон	1	1,163.3			1	1,163.3				
2	Авлага үүсгэсэн, он дамжсан авлагатай байна	1	5,549.2							1	5,549.2
3	Өр төлбөр үүсгэсэн, он дамжсан өр төлбөртэй байна	1	2,290.3							1	2,290.3
4	Худалдан авалтыг И баримтаар баталгаажуулаагүй	1	5,601.3					1	5,601.3		
Дүн		4	14,604.1	-	-	1	1,163.3	1	5,601.3	2	7,839.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	1,420,536.5							1	1,420,536.5
Дүн		1	1,420,536.5	-	-	-	-	-	-	1	1,420,536.5
Нийт дүн		5	1,435,140.6	-	-	1	1,163.3	1	5,601.3	3	1,428,376.0